



МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дугаар сарын 23-ны өдөр 17:00 цагт Улаанбаатар хот, компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/mandaldaatgal/> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдав. Санал хураалт болон асуултыг <https://www.stock.mandal.mn/> цахим хаягаар хураав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: З.Цэндсүрэн /Комиссын дарга/

Гишүүд: А.Ундрал

Б.Баяржаргал

Л.Насанжаргал

Д.Энхсүрэн

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 45

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 539,990,013 ширхэг

Хурлын ирц: 86.5 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2020 оны 03 сарын 12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2020 оны 03 сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр 2020 оны 03 сарын 17-ны өдөр, 2020 оны 04 сарын 01-ны өдөр, 2020 оны 04 сарын 08-ны өдрүүдэд тус тус мэдээллэснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2020 оны 03 сарын 18-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2020 оны 04 сарын 01-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Шинэ төрлийн коронавирус 2020 оны 04 сарын 23-ны өдрийн байдлаар дэлхийн 212 гаруй улсад бүртгэгдэж нийт 2,6 сая хүн уг өвчний халдвар авч, 184,0 мянга гаруй хүн уг өвчинөөр нас барж, 717,0 мянга гаруй хүн эдгэсэн, Монгол улсын хувьд 35 хүн уг өвчний халдвар авч 8 хүн эдгэсэн байна. Шинэ төрлийн коронавирустай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор олон нийтийн арга хэмжээг 2020 оны 04



сарын 30-ны өдөр хүртэл зохион байгуулахыг хориголсон мөн Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаат компаниудыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар явуулахыг зөвлсөний дагуу энэ удаагийн “Мандал Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийх болсоныг тайлбарлав.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ө.ганзориг нээлтийн үг хэлсэнээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2019 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3 дугаар асуудал: Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

5 дугаар асуудал: Компанийн ТУЗ-ийн нэг гишүүн өөрийн хүсэлтээр ажлаа хүлээлгэн өгч байгаа тул ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг танилцуулж сонгох;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2019 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2019 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2019 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлогыг 28.9 тэрбум, Орлогод тооцсон хураамж 16.4 тэрбум, Нөхөн төлбөр 5.4 тэрбум, Хөрөнгө оруулалтын орлого 3.7 тэрбум, Үйл ажиллагааны зардал 7.7 тэрбум, Цэвэр ашгийг 5.9 тэрбум төгрөгт хүрсэн.

2019 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө 28.5 тэрбум, Авлага 6.3 тэрбум, Эздийн өмч 20.7 тэрбум, Өр төлбөр 20.0 тэрбум, Нийт хөрөнгө 40.7 тэрбум төгрөгт хүрсэн.



2019 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Хохиролын харьцаа 27%, Нийлмэл харьцаа 73% Эздийн өмчийн өгөөж (ROE) 32%, Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 16% байсан.

Түүнчлэн 2020 оны 1-р улирлын үр дүнгээ товч танилцуулсан бөгөөд 1-р улирлын байдлаар нийт хураамжийн орлого 9,4 тэрбум, цэвэр ашиг 1.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Түүнчлэн даатгалын салбарын 2019 оны тоймыг хүргэсэн бөгөөд санхүүгийн үр дүнгээр салбарт эзлэх байр суурийн хувьд Мандал Даатгал нь нийт хөрөнгийн хэмжээгээр 2-т, нийт мөнгөн хөрөнгийн хэмжээгээр 1-т, нийт хураамжийн орлогоор 2-т, цэвэр ашгийн хэмжээгээр 1-т тус тус жагсаж байна.

Түүнчлэн “Мандал Даатгал” ХК-ны хувьцааны үзүүлэлтийг танилцуулсан бөгөөд 2019 оны 11 сарын 25-ны өдрийн 298 тоот Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор хувьцаа хуваах хүсэлтийг зөвшөөрсөнөөр “Мандал Даатгал” ХК-ны нийт гаргасан хувьцааны тоо 6,243,016 ширхэгээс 624,301,600 ширхэг болж, хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөгөөс 10 төгрөг болж өөрчлөгдсөн, 2019 оны хаалтын ханш 50.39 төгрөг, Зах зээлийн үнэлгээ 31.5 тэрбум төгрөг, нийт 2019 онд 2.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, 2019 оны өдрийн дундаж арилжаа 9.3 сая төгрөг байсныг танилцуулав.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ны 2019 оны 12 сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 19/014 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ны 2019 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Грант Торнтон Аудит” компанийг сонгосон. “Гранд Торнтон Аудит”-ын фирм нь Олон улсын аудитын франчайз бөгөөд “Мандал Даатгал” ХК-ны санхүүгийн тайланг сүүлийн 4 жил хийсэн. Уг аудитлагдсан тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн болохыг 2020 оны 02-р сарын 28-ний өдөр баталгаажуулсан байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг



Танилцуулгын гол агуулга: 2019 он “Мандал Даатгал” ХК-ийн хувьд амжилттай жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэв. Мөн хараат бус аудиторыг томилох, санхүүгийн төлөвлөлт, үр дүнг хянахад ТУЗ-ийн зүгээс онцгой анхаарал хандуулан ажилладаг болохыг дурдсан байна. Түүнчлэн 2018 оны 12 сарын 12-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас томилогдсон ТУЗ нь улирлын хурлаа цаг хугацаанд нь хийж, 2019 онд нийт 9 удаа хуралдаж, 19 шийдвэр гаргасан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодууд улирал бүр тогтмол хуралдаж, компанийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байгааг онцолсон байна.

ТУЗ-ийн 2019 оны 12 сарын 19-ны өдрийн 19/019 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ны ажилчид дундаас олон жил идвэх зүтгэлтэй ажилласан, байгууллагад онцгой хувь нэмэр оруулсан, цаашид байгууллагад тогтвортой ажиллаж онцгой хувь нэмэр оруулах ажилчдыг сонгон шалгаруулж 125,0 сая төгрөгийн хувьцааг эзэмшүүлэхээр шийдвэр гаргасан тухай танилцуулав.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Л’анзориг

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оын 02 сарын 18-ны өдрийн ээлжит хурлын 20/001 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав. Нэгж хувьцаанд 4 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 2,497,206,400 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөр гаргасан. Ногдол ашгийг 2020 оны 06 дугаар сарын 30-ний дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

5 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн нэг гишүүн өөрийн хүсэлтээр ажлаа хүлээлгэн өгч байгаа тул ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг танилцуулж сонгох;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Нямдаваа овогтой Монсор 2020 оны 02 сарын 10-ны өдөр цаашид Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр ажиллах боломжгүй болсон гэдэг өргөдлийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгсөн. Тус хүсэлтийг ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдэд танилцуулсан бөгөөд 2020 оны 02 сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар Нямдаваа овогтой Монсор гишүүнийг ТУЗ-ийн үүрэг ажилаас чөлөөлж түүний оронд “Юу Эм Си Капитал” ХХК-ийг

төлөөлж Шаравпэлжээ овогтой Гантуяаг ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллуулах санал оруулсан. Тус өдрийн ТУЗ-ийн шийдвэрээр Шаравпэлжээ овогтой Гантуяаг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгуулах шийдвэр гарсаныг танилцуулав.

Асуулт, Хариулт

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлсэнийг зарлаж тооллогын комиссийн даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал явагдаж байгаа тул бүх асуултанд хариулах боломжгүй, асуултуудийг агууллагын хувьд ижил болон олон давхцсан асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1: “Мандал Даатгал” ХК нь энэ хямралын үед ямар стратеги төлөвлөгөөтэй ажиллах вэ? Хямралын үед ямар арга хэмжээ авах вэ?

Хариулт ХЭХ-ын дарга Ө.Ганзориг: “Мандал Даатгал” ХК-ны төлөөлөн удирдах зөвлөл 2020 оны 3-р сард Гүйцэтгэх удирдлагад хямралын үед баримтлах үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийг боловсруулж ажиллах үүрэг даалгавар өгсөн. Covid-19 буюу коронавирусын цар хүрээ цаашид нэмэгдэх эсэх, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, эдийн засаг богино хугацаанд эргэн сэргэх эсвэл энэ нөхцөл байдал цаашид үргэлжилсээр байх уу гэдэг нь одоогоор тодорхойгүй байна. Тиймээс Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэрэв коронавирусын тархалт нэмэгдэх, урт хугацаанд эдийн засаг хямравал “Мандал Даатгал” ХК үүнд бэлэн байх стратеги, төлөвлөгөө боловсруулахыг үүрэг болгосон. Гүйцэтгэх удирдлага хямралын үед авч хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөө боловсруулан ажиглаж байгааг түрүүн илтгэлдээ дурьдсан. Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн гол чиглэл нь “Мандал Даатгал” ХК нь энэ хямралын үед уян хатан, ямар ч гэнэтийн цохилтон бэлэн байх ёстой гэж үзсэн. Нэг зүйлийг тодруулж хэлэхэд коронавирусын улмаас хохироогүй компани бараг байхгүй харин “Мандал Даатгал” ХК-ны хувьд ямар нэг банк болон санхүүгийн байгууллагаас авсан зээл байхгүй, ямар нэг их хэмжээний төлбөр төлөх үүрэг хүлээгээгүй, харин ч мөнгөн хөрөнгө их байгаа болон одоогийн байдлаар томоохон харилцагч нар даатгалын гэрээгээ сунгасан байгаа байдалтай байна. Худалдааны болон үйлчилгээний салбарыг бодвол даатгалын салбар энэ хямралд арай зөөлөн өртөж байгааг тайлбарлав.

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Одоогоор коронавирустай холбоотой нөхцөл байдал өдөр тутам өөрчлөгдөж байгаа. Цаашид ямар байх нь тодорхойгүй байгаа ийм үед “Мандал Даатгал” ХК-ны удирдлага цаг үедээ тохирсон хамгийн зөв гэж үзсэн, мөн хамгийн шилдэг гэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Үүний нэг жишээ нь ажилчдын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилчдын ур чадварыг сайжруулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна.

Асуулт 2: Хувьцааны ханш яагаад өсөхгүй байна вэ?

Хариулт ХЭХ-ын дарга Ө.Ганзориг: Олон улс оронд даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудтай харьцуулахад “Мандал Даатгал” ХК-ны хувьд хувьцааны ханш харьцангуй бага унсан буюу бараг унаагүй гэж хэлж болно. Сүүлийн 3 сарын хугацаанд коронавирус тархсантай холбоотой хувьцаат компаниудын хувьцааны ханш маш их унасан байгаа. Монголын хөрөнгийн биржид арилжаанд орж байгаа хувьцаат компаниудын хувьцаа яагаад өсөхгүй байна вэ гэдэг нь коронавирус тархахаас өмнө байсан асуудал. Сүүлийн үед IPO



хийсэн компаниудын хувьцаа бүгд унасан, харин “Мандал Даатгал” ХК-ны хувьд харьцангуй уналт бага байгаа. Яагаад хувьцаат компаниудын хувьцааны үнэ унаж байна гэхээр хөрөнгийн биржид арилжаанд орж байгаа ихэнх хүмүүс богино хугацааны хөрөнгө оруулалт хийх сонирхолтой, 3 сар магадгүй 6 сар болоод хувьцаагаа зарах сонирхолтой байгаа нь хувьцаат компаниудын хувьцааны ханш унахад нөлөөлж байна. Олон улсад тэтгэврийн сан болон бусад сангууд, хөрөнгийн биржид урт хугацааны хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгө оруулагч нар байдаг. Тиймээс энэ хөрөнгө оруулагч нарийг бий болгох шаардлагатай байгаа бөгөөд ингэхийн тулд хувийн тэтгэврийн санг Монгол улсад бий болговол хөрөнгийн зах зээлд жилд 100-200 тэрбум төгрөг орох боломжтой болж хувьцаат компаниудийн хувьцааны үнэ бодит ханшиндаа байх боломжтой болно. Бид хувьцааны ханшийг өсгөхийн тулд ёс суртахуунгүй хууль зөрчсөн үйлдэл хийхгүй харин хуулийн хүрээнд бид хувьцаагаа эргүүлэн худалдан авч халааслах боломж байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар хувьцаагаа халааслах тухай шийдвэр “Мандал Даатгал” ХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргаагүй байна.

Асуулт 3: “Мандал Даатгал” ХК ирэх жил ногдол ашиг тараах уу?

Хариулт ХЭХ-ын дарга Ө.Ганзориг: Коронавирус энэ хэвээр үргэлжилсээр байвал Монгол улсын эдийн засгийг эрэмдэг болгож магадгүй байна. Зарим эдийн засагч нар Монгол улсын эдийн засаг 10 хүртэл хувиар буурч магадгүй гэж үзэж байна. Одоогийн байдлаар худалдаа үйлчилгээний салбар 20-40 буурсан байгаа ийм нөхцөлд ирэх жил ногдол ашиг тараах эсэх талаар тодорхой хариу хэлэх боломжгүй байна.

Асуулт 4: Ажилчдад 125,0 сая төгрөгийн хувьцаа тараасан гэсэн ямар шалгуураар хэдэн ажилтан өгсөн бэ? Ямар үр дүн хүлээж байгаа вэ? Хувьцааг ямар хэлбэрээр олгосон бэ? Энэ жил мөн ажилчдад олгох уу?

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: “Мандал Даатгал” ХК нь анх үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн ажилчдад хувьцаагаа эзэмшүүлэхийг зорьж байсан. 2018 онд хувьцаат компани болсоноор энэ бүхэн биелэх боломжтой болсон. Бид 2019 онд нийт 8 ажилтанд хувьцаа олгохоор болсон ингэхдээ үндсэн хоёр шалгуур тавьсан. 1-рт удаан хугацаанд үнэнч шударгаар бүтээлчээр ажилласан 2-рт тухай жил компанийн ашигт ажиллагаа болон үйл ажиллагаанд онцгой хувь нэмэр оруулсан. Нийт олгосон 8 хүний хувьд харилцан адилгүй хувь хэмжээгээр хувьцаа эзэмшүүлсэн бөгөөд энэ нь тухайн ажилтаны ажлын хариуцлага болон бүтээмжтэй холбоотой юм.

Бид ямар хэлбэрээр олгох вэ гэдгийг маш их судалсан бөгөөд олон хувилбар байсанаас манай нөхцөлд хамгийн тохиромжтой гэж үзсэн хувилбар нь зах зээлээс хувьцааг худалдан авч ажилчдад өмчлүүлэх нь тохиромжтой гэж үзсэн. Энэ нь тухайн ажилтаны өмнө хийсэн үр дүнг үнэлж өгч байгаагаас гадна тодорхой хугацаанд мөн байгууллагад үр бүтээлтэй ажиллах нөхцөл зааж хэрэв уг нөхцөл биелэхгүй бол компани буцааж авахаар гэрээ байгуулсан.

Бид энэ хөтөлбөрийг жил болгон хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ гэхдээ одоогийн нөхцөл байдалд энэ жил энэ хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж хэлэхэд арай эрт байна. Учир нь эдийн засгийн нөхцөл байдал цаашид ямар байх нь тодорхойгүй байгаа учраас бид энэ жил ажилчдад хувьцаа эзэмшүүлэх эсэх шийдвэрийг оны өмнө гаргаад та бүхэнд мэдэгдэх болно.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

3 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 539,990,013 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь нь зөвшөөрсөн санал өгөв.

5 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн ТУЗ-ийн нэг гишүүн өөрийн хүсэлтээр ажлаа хүлээлгэн өгч байгаа тул ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох саналыг батлахад санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 529,430,721 ширхэг хувьцааны санал буюу 98.04 хувь нь зөвшөөрсөн санал өгөв.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Толоолон удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандал Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга индэр дээр гарч хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хаалтыг үгийг хэлсэнээр 18 цаг 26 минутанд хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ЭНХТҮВШИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:

Ө.ГАНЗОРИГ

Хурлын дарга